

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОДГЭРЭЛИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.6-ЫН ХҮРЭЭНД:							
1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах							
1.	Их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 1416 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнд дүн шинжилгээ хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2023 оны хяналт шалгалтаар хууль сахин мөрдөлтийн түвшин 65.6%, эрсдэл үүсэх магадлал 34.4% байсан.	100%	Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/78 дугаар тушаалаар баталсан Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай тушаалыг тус тус үндэслэн 2025 онд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр улсын хэмжээнд хийгдэх төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 6 удирдамжийг боловсруулан, ХХҮЕГ болон НДЕГ-т яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/77 дугаартай албан бичгээр хүргүүлэв. Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр 719 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээс 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 386 буюу 53,7 хувийг хамаарч хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Урьдчилан сэргийлэх	2025.01.02- 2025.06.20	100%

					хяналт шалгалтад 501 объект хамрагдсан байна. Удирдамжид заасан хугацаанд хяналт шалгалтуудыг эхлүүлж, улсын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.		
2.	Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлах	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2024 онд уул уурхай, нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхлэгч 186 ААНБ-д хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын дүнг үндэслэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах, талаар арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.	50%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 08-07/03 дугаартай “Уул уурхай, олборлолт, хуурай замаар хийгдэх ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг боловсруулж, аймаг, дүүргийн хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдад хүргүүлэв. Хяналт шалгалт үргэлжилж байна.	2025.01.02- 2025.06.20	50%
2.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагатай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Үзлэгт хамрагдсан 25 - аас дээш ажилтантай ААНБ (тоо)	Өмнө нь улсын үзлэг хийгдэж байгаагүй.	50%	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн улсын үзлэг шалгалтыг 2025 оны 2,3 дугаар улиралд зохион байгуулахаар газрын төлөвлөгөөнд тусгасаны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар “Улсын үзлэг зохион байгуулах тухай” тушаал гаргаж, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хийхээр зохион байгуулсан.	2025.01.02- 2025.06.20	50%

4.	Иргэний өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	2024 онд 14 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна.	100%	2025 оны эхний хагас жилд иргэнээс ирүүлсэн 9 өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна. Иргэний өргөдөл, гомдлын дагуу Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч А.Урангуатай хамтран Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд 5 заалттай албан шаардлага хүргүүлсэн байна. Мөн өргөдөл, гомдлын дагуу нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч П.Хорлоотой хамтран Чингэлтэй дүүргийн 39 дүгээр цэцэрлэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, өргөдөлд албан бичгээр хариу хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.20	100%
5.	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийн дагуу хийгдэх ажил	Ирсэн бичгийн шийдвэрлэлт (хувь) Зөрчил арилгалт (хувь)	2024 онд 32 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна.	100%	2025 оны эхний хагас жилд аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 41 албан бичигт хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна.	2025.01.02-2025.06.20	100%
6.	Удирдах дээд байгууллага, албан тушаалтны үүрэг даалгаврын дагуу хийгдэх ажил	Үүрэг даалгаврын тоо	Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж ажилласан.	100%	1.Яамны ажилтан, албан хаагчдын тэмцээний дартсын төрөлд оролцож, багаараа тэргүүн байранд орсон амжилттай оролцсон. 2.Яамны архивын улсын үзлэгийн бэлтгэл ажилд 4 удаа орж ажилласан. 3.Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталсан 08-07/13 дугаартай удирдамжаар Аргал ойл ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 07/00-02/006-04 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. Мөн тус аж ахуйн	2025.01.02-2025.06.20	100%

					нэгж, байгууллагад эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Ж.Сарантуяа Зөрчлийн тухай хуулийн 10.15.5-ээр 750,000 төгрөгийн торгууль ногдуулж, 100% биелсэн байна. Мөн Сод монгол групп ХХК-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч О.Алтантуяатай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 16 заалттай албан шаардлага хүргүүлж ажилласан.		
7.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн цахим системд 2024 онд бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэлд дүн шинжилгээ хийх (салбараар)	ҮОХХ-ын тайлан-1	2024 онд нийт 711 тохиолдолд 809 хүн үйлдвэрлэлийн осол хурц хордлогод өртсөн. ҮОХХ-ын дүн мэдээнд шинжилгээ хийж, ҮСХ-д улирал бүр тайланг хүргүүлсэн байна.	100%	2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийт 236 тохиолдолд 251 хүн үйлдвэрлэлийн осолд өртөж, үүнээс 22 хүн нас барсан, 229 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 8,7 хувь байна. - Уул уурхай, олборлолтын салбарт 36 ослын тохиолдолд 36 хүн өртөж, үүнээс 5 хүн нас барж, 31 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 15,2 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт гарсан байна. - Барилгын салбарт 13 ослын тохиолдолд 13 хүн өртөж, үүнээс 3 хүн нас барж, 10 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 5,5 хувийг хамаарч байна. - Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 32 ослын тохиолдолд 32 хүн өртөж, үүнээс 1 хүн нас барж, 31 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 13,5 хувь нь тус салбарт гарсан байна. - Тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт 29 ослын тохиолдолд 32 хүн өртөж, үүнээс 2 хүн нас барж, 30 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 13,5 хувийг хамаарч байна.	2025.01.02-2025.06.20	100%

					Ослын 1 тохиолдолд 2 хүн өртсөн бүлэг осол 6, 3 хүн өртсөн бүлэг осол 1, нийт 7 бүлэг осолд 15 хүн өртсөн байна. Нийт тохиолдлын 7 буюу 3 хувь нь бүлэг осол байна. Унаж, бүдрэх халтирсны улмаас үйлдвэрлэлийн осолд өртсөн нь нийт шалтгааны 33.1 хувийг, эд зүйлд хавчуулагдах шалтгаан 14,3 хувийг, унаж байгаа эд зүйлд цохигдох шалтгаан 8.7 хувийг тус тус эзэлж байна. Осол гарахад нөлөөлсөн хүчин зүйлийн 47,4 хувь нь хүний, 32,6 хувь нь ажлын байр, орчны, 9,5 хувь нь техник технологийн, 10,8 хувь нь удирдлагын тогтолцооны хүчин зүйлээс хамаарсан байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн аймаг, дүүргээс Өмнөговь аймаг 34 буюу 14,5 хувь, Баянгол, Хан-Уул дүүрэг тус бүр 25 буюу 10,6 хувийг хамаарч байна. 2025 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар 10,000 хүнд ногдох хүндрэлийн коэффициент 0,15, ослын коэффициент 1,82, 100,000 хүнд оногдох нас баралт 1,5 байна.		
8.	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Дүн шинжилгээний тоо	100%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/46 дугаар Хяналтын хуудаст нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тушаалаар 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудаст Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийг шалгах асуумжийг нэмж батлуулсан. Хяналт хуудасны нэмэлт өөрчлөлтийн талаар хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад цахим зөвлөгөө өгсөн. Хэрэгжилтийн дүн шинжилгээ, төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтын танилцуулгад	2025.01.02-2025.06.20	100%

					үндэслэн 2025 оны 04 дүгээр улиралд хийгдэнэ.		
9.	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, хуулийн этгээдүүдийг хууль зүйн мэдээллээр хангасан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэсэн байна.	2024 онд 1 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гүйцэтгэсэн.	100%	Боловсролын яамны Салбарын хяналтын газрын шинжээч, улсын ахлах байцаагч Д.Өнөржаргалаас 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр харьяаллын дагуу шилжүүлэх талаар гаргасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж буй зөрчлийн БЯ20250403/02 дугаартай гомдол, мэдээлэл/хэрэг/-тэй 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр танилцаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулж, 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Нийслэлийн прокурорын газарт, мэдэгдэх хуудсыг иргэнд тус тус хүргүүлсэн.		
3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
10.	Олон Улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулах	Төслийн хүрээнд 1 сургалт зохион байгуулсан байна.	2024 онд “Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих техникийн туслалцааны төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын улсын байцаагчдыг болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 170 хүн хамрагдсан.		Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад зориулсан “Албадан хөдөлмөр” товч лавлах болон 07.1.1.а кодтой хяналтын хуудсаар шалгалт хийх практик удирдамжийн талаарх ойлголт өгөх танхим, цахим хосолсон сургалтыг ОУХБ, Бриж-2 төслийн багтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 76 улсын (ахлах) байцаагчийг хамруулав.	2025.01.02-2025.06.20	100%

11.	Бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан сургалтыг зохион байгуулахад оролцох	- Зохион байгуулсан сургалтын тоо - Хамрагдсан хүний тоо	2023 онд ХАБЭА-н Үндэсний чуулганд зохион байгуулалтын ажлын хэсэгт оролцсон.	100%	Газрын тосны салбарт аж ахуйн нэгж байгууллагуудад гардаг нийтлэг зөрчил, болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан ба хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2025.01.02- 2025.06.20	100%
12.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн явц, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /хувь/- 90-ээс доошгүй	2024 оны эхний хагас жил 91%, сүүлийн хагас жилд 93,4%-ын үнэлгээтэйгээр тус тус ажлаа дүгнүүлсэн.	100%	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, сарын тайланг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	2025.01.02- 2025.06.20	100%
13.	Удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгавраар ажиллах	Үүрэг даалгаврын тоо	Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж ажилласан.	100%	1.Газрын зохион байгуулалтын баримт бичгүүдийн эмх, цэгц, дугаар олгох ажлыг хариуцан ажилласан. 2.Газрын 2025 оны 01 дүгээр улирлын сарын тайлан, бодлогын баримт бичгүүдийн тайлангууд, 7 хоногийн мэдээг боловсруулж, холбогдох ажилтнуудад хүргүүлж ажилласан. 3.Сайдын албан даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгч ажилласан. 4.2024 онд Салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлж буй орон нутаг, нийслэл, дүүрэгт шинээр эрх авсан хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын 21 улсын (ахлах) байцаагчдын үнэмлэх, тэмдэг олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн судалгаанд оруулж ажилласан байна. 5.Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт дахь	2025.01.02 2025.06.20	100%

					"Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-ын дагуу салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлж буй аймаг, дүүргийн 21 улсын байцаагч нарт улсын (ахлах) байцаагчийн эрх олгож, 15 улсын (ахлах) байцаагчийн эрхийг цуцалсан байна. 6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулган"-нд оролцох 71 улсын (ахлах) байцаагчийн нэрсийг холбогдох газарт нь хүргүүлж, оролцогчдын оролцоог хангаж ажилласан. 7.Яамны албан хаагчдын ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Rhetoric буюу илтгэх урлаг" сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан.		
14.	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон орон нутгийн салбар нэгжүүдтэй хамтран үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Аймаг, дүүргийн 15 төв хамрагдана.	Өмнө нь асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үзлэг шалгалт хийгдээгүй байна.	100%	Асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын мөрдөж буй стандартын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар тушаалаар удирдамж, үзлэг шалгалтад хамрагдах 15 асрамж, халамжийн төвийн нэр, үзлэг шалгалт хийх асуумж, судалгааны хамт аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж, үзлэг шалгалтын үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 07-22-ны өдрүүдэд зохион байгуулж, хяналт шалгалтын танилцуулга, тоон мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналыг дотоод бичгээр холбогдох газруудад тус тус хүргүүлсэн.	2025.01.23	100%

					Үзлэг шалгалтын үр дүнд Баянзүрх дүүргийн Өнөр бүл хүүхдийн төвд амьдарч буй ДЦП мөчний чангарсан саажилт, F73 хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байдаг бүтэн өнчин, 19 настай эрэгтэй Т.С, мөн тархины саажилттай, F2 хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, ДЦП тулгуур эрхтний гажиг гэсэн хавсарсан оноштой, сэтгэцийн эмчийн хяналтад байдаг бүтэн өнчин, 20 настай, эмэгтэй Б.А нарын нөхцөл байдалтай танилцсаны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”-ын 4.1 дэх хэсэгт “үйлчлүүлэгчийг насны байдал, тусгай хэрэгцээ, нөхцөл, асруулах хэлбэр, чиглэлээр нь бусад асрамжийн газруудад төрөлжүүлэн шилжүүлж болно” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй асруулагч Т.С, Б.А нарыг Баруун бүсийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн газарт асруулахаар шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025.01.23-ны өдрийн 02/246 дугаартай албан бичиг хүргүүлж ажилласан ба улмаар нөхцөл байдлын шинжилгээ хийж, нэг асруулагчийг тус асрамжийн газарт шилжүүлсэн байна.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
-----	----------------------------------	---------------------	--------------	-----------------	-------------------------	--------------------------------	-------------------------

15.	Газраас 2024 онд гаргасан зохион байгуулалтын баримт бичгийг архивлах	7 баримт бичиг	2023 оны 13 төрлийн баримт бичгүүдийг стандартын дагуу архивлаж яамны архивт хүлээлгэж өгсөн.	100%	Салбарын хяналтын газрын 2024 онд гаргасан зохион байгуулалтын 7 төрлийн баримт бичгийг стандартын дагуу цэгцэлж, товьёглож, үдэж архивын ажилтанд хүлээлгэж өгөхөд бэлэн болгосон. Мөн улсын ахлах байцаагчийн албан шаардлага, акт, дүгнэлт, зөвлөмж, салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар, шийдвэр зэргээр цахим архив үүсгэж ажилласан.	2025.01.02-2025.06.20	100%
16.	Хэвлэмэл хуудасны хадгалалт, зарцуулалтыг хариуцаж, хяналт тавих, хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, тэмдгийн дардасны судалгаа гаргах	162 улсын (ахлах) байцаагч	2024 онд 32 улсын (ахлах) байцаагч нарт улсын (ахлах) байцаагчийн эрх олгож, 35 улсын (ахлах) байцаагчийн эрхийг цуцалсан.	100%	1.Засгийн газрын 06 дугаар тогтоолын "Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-ын 1.12-т төрийн захиргааны төв байгууллага нь хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардасны судалгааг авч, хяналт тавих заалтын дагуу салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлж буй яам, агентлаг, орон нутаг, нийслэл, дүүргийн 162 улсын (ахлах) байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардасны судалгаа гаргаж ажилласан. 2.Яамны нэр, зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор яам, харьяа агентлаг, аймаг, дүүрэгт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, нэгжийн удирдлага, улсын (ахлах) байцаагчдын 221ш тэмдгийн дардасны резин, үнэмлэхний хавтасны нэрийг солиулж холбогдох агентлагууд, улсын (ахлах) байцаагчдад хүлээлгэн өгч, бүртгэлжүүлж ажилласан байна.	2025.01.02-2025.06.20	100%

4. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
17.	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт, дадлага эзэмшүүлэх нэгдсэн сургалт, семинарт хамрагдах	1 сургалт	2024 онд гадаадын 1, үндэсний 2 чадавхжуулах сургалтад хамрагдана.	100%	ОУХБ, Бриж-2 төслийн хүрээнд Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад зориулсан "Албадан хөдөлмөр" товч лавлах болон 07.1.1.а кодтой хяналтын хуудсаар хяналт шалгалт хийх практик сургалтад хамрагдав.	2025.01.02-2025.06.20	100%
18.	Монгол бичиг бие даан сурах	Бие дааж сурах	Монгол бичгийн дунд шатны мэдлэгтэй.	100%	Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах хөтөлбөрийн хүрээнд бие даан уншиж, бичих чадвараа сайжруулсан.	2025.01.02-2025.06.20	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

...../Г.ОДГЭРЭЛ/
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

**ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОДГЭРЭЛИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Салбарын хяналтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаа- жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

**1.САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ,
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.6-ЫН ХҮРЭЭНД:**

Нэг. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах

1.	Их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 1416 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнд дүн шинжилгээ хийх	55	10	65	65
2.	Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлах	60	10	70	70

2.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ

3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагатай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн улсын	55	10	65	65
----	---	----	----	----	----

	үзлэг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх				
4.	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд ХХҮЕГ, НДЕГ-ын улсын (ахлах) байцаагч нартай хамтран (Баруун, Төв, Зүүн, Говийн бүсэд) хяналт шалгалт хийх, орон нутгийн улсын байцаагчдын ажлыг газар дээр нь үнэлж, дадлагажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх	50	10	60	60
5.	Иргэний өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	55	10	65	65
6.	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийн дагуу хийгдэх ажил	60	10	70	70
7.	Удирдах дээд байгууллага, албан тушаалтны үүрэг даалгаврын дагуу хийгдэх ажил	60	10	70	70
8.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн явц, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах	55	10	65	65
9.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн цахим системд 2024 онд бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэлд дүн шинжилгээ хийх (салбараар)	50	10	60	60
10.	Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Ажиллах хүч шилжилт хөдөлгөөний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд, тэдгээрийг дагалдаж гарах Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд санал өгөх	50	10	60	60
11.	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх	55	10	65	65
12.	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, хуулийн этгээдүүдийг хууль зүйн мэдээллээр хангах	50	10	60	60
3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ					
13.	Олон Улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор	55	10	65	65

үлсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулах				
14.	Бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан сургалтыг зохион байгуулахад оролцох	55	10	65
Дундаж оноо:				
64,6				

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1	2	3	4	
15.	Хөдөлмөрийн хяналтын үлсын байцаагчдыг чадваржуулах сургалт, дадлага эзэмшүүлэх нэгдсэн сургалт, семинарт хамрагдах	100%	13	13
16.	Монгол бичиг бие даан сурах	100%	14	14
Дундаж оноо				
13,5				

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		Дундаж оноо			
				Мэргэжлийн ур чадвар 1.	Мэргэжлийн ур чадвар 2.	Мэргэжлийн ур чадвар 3.	Дундаж оноо		
1.	Хандлага, ёс зүй	7	7						
2.	Дүн шинжилгээ хийх	6	6						
3.	Асуудал шийдвэрлэх	6	6						
4.	Хариуцлагатай байдал	7	7						
5.	Ажлын цаг ашиглалт	6	6						
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)									
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	6,3	6,3						
7.	Мэргэжлийн ур чадвар 2.								
8.	Мэргэжлийн ур чадвар 3.								
Дундаж оноо									
6,3									

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
1.	Хандлага, ёс зүй	6,9
2.	Багаар ажиглах	6,6
3.	Хариуцаа	7,1
Дундаж оноо		
6,9		

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	67,6
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13,5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,3
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	6,9
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		91,3

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Салбарын хяналтын газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Б.Батзориг/
(албан хаагчийн нэр)

2015.06.13.....(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Хөдөлмөрийн хяналтын бодлого төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Г.Одгэрэл/
(албан хаагчийн нэр)

2015.06.13.....(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/В.Түвшинжаргал/
(албан хаагчийн нэр)

2015.06.20.....(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Б.Баянжаргал /
(албан хаагчийн нэр)

2015.06.20.....(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Л.Мөнхзул/
(албан хаагчийн нэр)

2015.06.20.....
(огноо)

